



**МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/421

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Шинэ Ховд агро парк" төслийн хүрээнд 140 га газрын усалгаатай газар тариалангийн усалгааны усан хангамжийн эх үүсвэр гаргах зорилгоор 83,000,000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх төсөл арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд сонгон шалгаруулалт хийж зохион байгуулах ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д үүрэг болгосугай.

3. Тус арга хэмжээнд зарцуулах 83,000,000 төгрөг (наян гурван сая)-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 7 дугаар хуралдааны 7/02 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээ, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.10 дахь ("Услалтын системүүдийг үе шаттайгаар сэргээн засварлаж, өргөжүүлэн төмс хүнсний ногоо, малын тэжээлийн ургамал, үр тарианы тариалалтыг нэмэгдүүлнэ") заалтад тусгагдсан төсөл арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх) нарт зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 2125



**УСАЛГААТАЙ ГАЗАР ТАРИАЛАНГИЙН УСАЛГААНЫ УСАН
ХАНГАМЖИЙН ЭХ ҮҮСВЭР ГАРГАХ ТӨСВИЙН ЗАДАРГАА**

№	Төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Мөнгөн дүн
1	Ф219 мм хоолой бүхий гүний худаг	Ш	1	35.000.000
2	Ф273 мм хоолой бүхий гүний худаг	Ш	1	48.000.000
	Нийт дүн			83.000.000

-oOo-